

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2013 оны 2-р сарын 27-ны байдлаар*


2013 оны 2-р сарын 27-ны байдлаар гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 4.7 хувь, өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 0.5 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 8.9-11.4 хувь, хонины ястай махны үнэ 11.1 хувь, адууны махны үнэ 8.0 хувь, ямааны махны үнэ 13.8 хувиар өссөн байна.

Махны үнийг өмнөх 7 хоногийн *᠗᠔ᠶ᠋ᠠᠭ* үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 1.4-2.0 хувь, адууны махны үнэ 0.6 хувь, хонины ястай махны үнэ 0.8 хувиар *᠒ᠶ᠋ᠠᠨ* *ᠠᠲᠦ*, ямааны махны үнэ *᠔ᠶ᠋ᠢᠨ* *ᠠᠭᠠᠭ*.

2013 оны 2-р сарын 27-ны байдлаар 1 кг хонины /ястай/ махны үнэ дунджаар 7738 төгрөг, хонины цул мах 7833 төгрөг, үхрийн /ястай/ мах 8529 төгрөг, үхрийн цул мах 9414 төгрөг, ямааны мах 5933 төгрөг, адууны мах 6240 төгрөгийн үнэтэй байлаа (Зураг 1; 2).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ **Зураг 2.** Цул махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад задгай 1-р зэргийн гурилын үнэ 0.2 хувиар өссөн байв.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад дээд гурилын үнэ тогтвортой байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар элсэн чихрийн үнийг өмнөх сарын дундаж үнэтэй бол*ᠶ*, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цагаан будааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй бол*ᠶ*, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна (Зураг 3).

Зураг 3



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 24.1 хувь, сонгины үнэ 1.2 бодомжлох өөрчлөлтэй агаар, төмсний үнэ 1.7 хувь, өмнөх сарын дундаж үнэ 4.1 хувиар өсч байна.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад бодомжлох өөрчлөлтөд үнэ 1.9 хувь, луувангийн үнэ 3.4 хувь, сонгины үнэ 1.6 хувиар өсч, байцааны үнэ тогтвортой байна.

Сүү, өндөг, ургамлын тос, цөцгийн тосны дундаж үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 500 граммын савласан сүүний үнэ 13.3 хувь, 1 литрийн савласан сүүний үнэ 3.8 хувь, задгай сүүний үнэ 2.0 хувиар өсчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 500 граммын савласан сүүний үнэ 10.1 хувиар өссөн байна.

Ургамлын тосны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй болон, өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад тогтвортой байна. Цөцгийн тосны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 7 хоногийн өөрчлөлтөд үнэ 7.0 хувиар өсч, байцааны үнэ тогтвортой байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, хонь, ямаа, үхрийн мах, цагаан будаа, шингэн сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 630-920 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Сүхбаатар аймагт 90 төгрөгөөр өсч, Архангай аймагт 10 төгрөгөөр өсч, бусад аймагт өөрчлөлт байхгүй байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 630 төгрөг байхад, Говь-Алтай, Увс, Ховд, Дундговь, Өмнөговь, Хэнтий аймагт 900 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Дархан-Уул, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт 200-1700 төгрөгөөр өсч, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорнод аймагт 100-750 төгрөгөөр буурчээ. Хонины махны үнэ Орхон аймагт 7500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Өвөрхангай аймагт 5200 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Дархан-Уул, Сэлэнгэ аймагт 300-1500 төгрөгөөр өсч, Увс аймагт 500 төгрөгөөр буурчээ. Үхрийн махны үнэ Орхон, Дархан-Уул, Дорноговь, Төв аймагт 8000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 5500 төгрөгөөр зарагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Баян-Өлгий, Архангай, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий аймагт 100-500 төгрөгөөр өссөн бол, Говь-Алтай, Увс, Говьсүмбэр аймагт 300 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Говь-Алтай, Говьсүмбэр аймагт хямд 4500 төгрөг байхад, Дархан-Уул аймагт 6500 төгрөгөөр зарагдаж буй нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар малын сүү аймгуудад 1000-2500 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байна. Сүүний үнэ Баянхонгор, Хэнтий аймагт 100-200 төгрөгөөр өссөн бол, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Дорнод аймагт 100-200 төгрөгөөр буурсан байна. Өвөрхангай, Өмнөговь, Завхан аймагт хамгийн /2500 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2013 оны 2-р сарын 27-ны байдлаар цагаан будааны үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Сүхбаатар аймагт 20 төгрөгөөр өсч, Өмнөговь аймагт 50 төгрөгөөр буурсан байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 1500-1800 төгрөгөөр худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад Сүхбаатар аймагт 10 төгрөгөөр өссөн байна. Аймгуудад элсэн чихэр 1 кг нь 1500-1800 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.